



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|-----------|----|
| 23. | Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 01 | 57 |
|-----|---|-----------|----|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|----------------------------------|------------|----|
| 24. | Үндэсний зөвлөл байгуулах тухай | Дугаар 163 | 58 |
| 25. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 01 | 59 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|----|
| 26. | Олон улсын спортын тэмцээн, наадам зохион байгуулах тухай | Дугаар 376 | 60 |
| 27. | Тусгай зориулалтаар 2015 онд агнах агнуурын амьтны тоог тогтоох тухай | Дугаар 377 | 62 |
| 28. | Эрх шилжүүлэх тухай | Дугаар 393 | 63 |
| 29. | Журамд нэмэлт оруулах тухай | Дугаар 398 | 63 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр	Дугаар 01	Улаанбаатар хот
--------------------------------------	-----------	-----------------

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд



өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар
хот

**Үндэсний зөвлөл байгуулах
тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Ази, Европын дээд түвшний арван нэгдүгээр уулзалтыг 2016 онд Улаанбаатарт зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүргээр хангах Үндэсний зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг нь хавсралтаар баталсугай.

Хоёр. Үндэсний зөвлөлийн ажлын хэсгүүд болон ажлын албыг байгуулан ажиллуулах, Үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг нь сар бүр танилцуулж ажиллахыг Үндэсний зөвлөлийн даргад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2014 оны 12 сарын 30-ны өдрийн
163 дугаар зарлигийн хавсралт

Үндэсний зөвлөлийн дарга:

-Монгол Улсын Ерөнхий сайд



Үндэсний зөвлөлийн дэд дарга:

- Гадаад хэргийн сайд;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

Үндэсний зөвлөлийн гишүүд:

- Сангийн сайд;
- Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
- Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх;
- Ерөнхийлөгчийн Олон нийтийн харилцааны бодлогын зөвлөх;
- УИХ-ын даргын Ахлах зөвлөх;
- Ерөнхий сайдын Ахлах зөвлөх;
- Ерөнхий сайдын олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн зөвлөх;
- ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга;

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга:

- ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 01 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Нэг. 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын түүхт 70 жилийн ой 2015 онд тохиож буйтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Ч.Сайханбилэг)-т чиглэл болгосугай.

1. 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын түүхт 70 жилийн ойг 2015 онд улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх;

2. Ойг угтан түүхэн ялалтын үнэ цэнэ, цэрэг эрсийнхээ байгуулсан гавьяаг сурталчлах, мөнхжүүлэх, дайнд оролцогсод, ахмад дайчдадаа хүндэтгэл үзүүлэх, тэдний эх оронч сэтгэл, зүтгэлийг залуу хойч үедээ өвлүүлэх, ойн медаль гаргах, улс түмний найрамдалт харилцаа, Зэвсэгт хүчний хамтын ажиллагааг баяжуулан хөгжүүлэхэд түлхэц өгөхүйц цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Хоёр. Энэхүү түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах зардлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар (Ч.Сайханбилэг)-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

**ЧИМЭДИЙН
САЙХАНБИЛЭГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 376

Улаанбаатар
хот

**Олон улсын спортын тэмцээн,
наадам зохион байгуулах тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 2015 онд олон улсын дараах тэмцээнийг зохион байгуулсугай:



- а) Нисэх загварын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн;
- б) “Чингис хаан-2015” жүдо бөхийн Гран-При тэмцээн;
- в) Дэлхийн шилдэг эмэгтэй шатарчдын Гран-При тэмцээн;
- г) Сонсголын бэрхшээлтэй иргэдийн шатрын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн;
- д) Туялзуур сэлэмний залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн;
- е) Хөл бөмбөгийн “Asian Cup-2015” Азийн цомын тэмцээн;
- ё) Волейболын эрэгтэйчүүдийн Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн;
- ж) Чөлөөт бөхийн “Mongolian open” тэмцээн;
- з) Тэшүүрийн “Mongolian open” тэмцээн;
- и) Софт теннисний “Mongolian open” тэмцээн;
- й) Практик буудлагын “Mongolian open-2015” тэмцээн;
- к) “Улаанбаатар марафон-2015” олон улсын гүйлтийн тэмцээн;
- л) Монгол туургатан бөхийн барилдаан;
- м) Олон улсын ахмадын спортын наадам.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан тэмцээний бэлтгэлийг бүрэн ханган зохион байгуулж, дүнг 2015 оны IY улиралд багтаан Засгийн



газарт танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Оюунгэрэлд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**

Ц.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 377

Улаанбаатар
хот

**Тусгай зориулалтаар 2015 онд
агнах агнуурын амьтны тоог
тогтоох тухай**

Амьтны тухай хуулийн 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Тусгай зориулалтаар 2015 онд угалз 40, тэх 60, халиун буга 15, саарал чоно 20, бор гөрөөс 10, зэрлэг гахай 10 толгойг агнуулахаар тус тус тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ**

С.ОЮУН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 393

Улаанбаатар
хот

Эрх шилжүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 12 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн авто замын ачааллыг зохицуулах зорилгоор замын хөдөлгөөний урсгал, тээврийн хэрэгслийн тоо, байгууллагуудын байршил, тэдгээрийн ажиллагсад, суралцагчдын тоо, түгжрэл ихээр үүсч байгаа зам, цаг хугацаа зэргийг харгалзан нийслэлд байршин үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, яам, Засгийн газрын агентлаг болон тэдгээрийн харьяа байгууллага, бусад төсөвт байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг зохицуулж байх эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Улаанбаатар хотод ажил эхлэх цагийг тогтоох тухай” Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 8 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 398

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



“Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4.1-д “4.1.54. Даатгалын өдөр–жил бүрийн 11 дүгээр сарын 24-ний өдөр” гэсэн заалт нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

САНГИЙН САЙД

Ж.ЭРДЭНЭБАТ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: tugii_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003